

## МОНГОЛ-ОРОС-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ХӨГЖИЛ

**Х.Эрдэнэчулуун\***, **Наталья Валерьевна Монгорова\*\***

**Хураангуй:** Өгүүлэлд Монгол, Орос, Хятад улсын худалдааны хөгжлийн асуудалд дун шинжилгээ хийж гурван талт Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудыг судалсан. Монгол, Орос, Хятад улсын 2016-2020 оны худалдааны өөрчлөлтийн динамикийг шинжлэн төслийг хэрэгжүүлэх нь гурван улсан худалдааны эргэлт нэмэгдүүлэхэд түлхэц өгнө.

**Түлхүүр үгс:** Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр, Монгол, Орос, Хятад. Худалдааны динамик.

### INTERNATIONAL TRADE DEVELOPMENT UNDER THE MONGOLIAN-RUSSIAN-CHINESE ECONOMIC CORDER PROGRAM

**Abstract:** The article analyzes the development of trade between Mongolia, Russia and China and examines issues related to the implementation of the Tripartite Economic Corridor Program. Analyzing the dynamics of trade changes in Mongolia, Russia and China in 2016-2020, the implementation of the project will help increase trade turnover between the three countries.

**Keywords:** Economic Corridor Creation Program, Mongolia, Russia, China. Dynamics of trade changes.

---

\* Улан-Баторский филиал РЭУ им. Г.В. Плеханова, (Email): erdenechuluunkh123@gmail.com

\*\* Улан-Баторский филиал РЭУ им. Г.В. Плеханова, (Email): nmongolova@mail.ru, <https://orcid.org/0000-0001-6288-4137>

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ерөнхийлөгч Ташкент (Узбекистан) хотноо Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын дээд хэмжээний уулзалт дээр 2016 оны 6-р сарын 23-нд “Монгол-Орос-Хятадын Эдийн Засгийн Коридор байгуулах Хөтөлбөр”-т (Хангай.Л, 2019) гарын үсэг зурсан.

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь Евразийн Эдийн Засгийн Холбоо, “Талын зам” санаачилга ба “Нэг бүс-Нэг зам” эдийн засгийн бүс”-ийн зөвлөмжийг харгалзан “Монгол-Орос-Хятад”-ын Эдийн Засгийн коридор хөтөлбөрийг боловсруулсан(цаашид - Эдийн засгийн коридор гэнэ).

Эдийн засгийн коридор байгуулах зорилго нь Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг өрсөлдөх чадварыг хангах, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх замаар гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино (Хангай.Л, 2019).

Эдийн засгийн коридорын хэтийн төлөв нь Тал тус бүрийн боломж, давуу талыг ашиглах, эдийн засгийн харилцан ашигтай эдийн засгийн хөгжлийн орон зайг бий болгох, бэхжүүлэх, тэдний хөгжил цэцэглэлт, дэлхийн зах зээл дээрх хамтарсан өрсөлдөх чадварыг бэхжүүлэх явдал юм.

Эдийн засгийн коридор бий болгох нь бүс нутгийн эдийн засгийн интеграцчлалыг гүнзгийрүүлэх, хөгжлийн стратеги болон дэд бүтцийн харилцан уялдаа холбоог хангах нөхцөлийг бүрдүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг тогтвортой, шат дараатай хөгжүүлэх, эдийн засгийн бодлогыг харилцан зохицуулах, хүмүүнлэгийн харилцааг бэхжүүлэхэд түлхэц болно.

Хөтөлбөрт 32 томоохон төсөл багтсан. Хөтөлбөрт тусгагдсан төслүүдийн хэрэгжилтийг урагшлуулахын тулд талууд бүх түвшинд зөвлөлдөж, хамтран ажиллаж байна. Гурван улсын холбогдох газрын дэд сайд нарын түвшинд хамтарсан ажлын хэсэг байгуулж, шинжээчдийн түвшинд уулзалт тогтмол зохион байгуулж байна.

“Эдийн засгийн коридор” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэн тэргүүний зорилтын нэг нь төмөр замын төв коридорыг шинэчлэх төсөл юм (Батцэцэг.Б, 2021). Энэ ажлыг эхлүүлэх, төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулахын тулд талууд Хамтарсан мэдэгдэл гарган ажлын төлөвлөгөөг тохиролцсон бөгөөд гурван улсын тэргүүн нарын дараагийн уулзалтын үеэр гарын үсэг зурахаар төлөвлөжээ.

Экспорт-импорт, транзит болон дотоодын тээвэрлэлтийг Орос, Хятадыг

холбосон 1110 км урт төмөр замаар гүйцэтгэдэг. Монгол Улс дотоодын төмөр замыг уртасгах, тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хэд хэдэн шинэ төсөл дээр ажиллаж байна. Тухайлбал, манай нүүрсний томоохон орд болох Тавантолгойг БНХАУ-тай холбох төмөр замын төсөл амжилттай үргэлжилж, 2022 он гэхэд ашиглалтад орно. Мөн Тавантолгойн ордыг гол замтай холбох төмөр зам 2021 онд ашиглалтад орно. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ОХУ-ын Ерөнхий сайд М.В.Мишустинтэй утсаар ярихдаа Монгол Улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төмөр зам, эрчим хүчний төслүүдэд Оросын компаниуд оролцоход нээлттэй гэдгийг онцлолоо (Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулна, 2021.11.10).

Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шинэ төмөр зам барихын зэрэгцээ “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийг шинэчлэх, хөгжүүлэх шаардлагатай байгаа асуудал байгаа. Энэхүү хувьцаат компани нь 1949 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Хобоот Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үндсэн дээр байгуулагдсан бөгөөд өнөөдөр техникийн шинэчлэл, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, оновчтой бүтэц зохион байгуулалтад оруулах зэрэг орчин үеийн хөгжилтэй хөл нийлүүлэхэд шаардлагатай олон ажил шийдлээ хүлээж байна. Мэдээж эдгээр асуудлыг “Улан-Баторская Железная Дорога” Хувьцаат Компаний 50 хувийг эзэмшдэг ОХУ-ын талтай хамтран шийдвэрлэх ёстой билээ.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ОХУ-ын Ерөнхий сайд М.В.Мишустинтэй утсаар ярихдаа “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн өрийн асуудлыг шийдвэрлэх, тээврийн үнэ тарифыг үе шаттайгаар чөлөөлөх тал дээр анхаарч ажиллаж байгаагаа тэмдэглэв (Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулна, 2021.11.10).


Боомтуудыг хөгжүүлэх, гааль, хорио цээрийн хяналтыг сайжруулах зорилгоор хилийн боомтуудын дэд бүтцийг бэхжүүлэх, ажлыг сайжруулах, ялангуяа Алтанбулаг, Улхьян худалдааны чөлөөт бүсийг хөгжүүлэх нь манай хоёр улсын ашиг сонирхолд нийцэж байгааг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ тэмдэглэв (Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулна, 2021.11.10).

Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр батлагдсан 2016 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 8274.4 сая ам.доллар байсан бол 2020 онд 55.6 хувиар өссөн буюу 12,875,2 сая ам.доллар, үүнээс экспорт 4,916,3 сая ам.доллараас 7,576,3 сая ам.доллар, импорт 3358,1 сая ам.доллараас

5298,9 сая ам.доллар болж өссөн байна.

Монгол Улсын хоёр хөрштэй хийсэн нийт гадаад худалдааны эргэлт 2020 оны байдлаар нийт худалдаа эргэлтийн 68.82 хувийг бүрдүүлж байгаагийн 11.32 хувь нь Орост , 57.5 хувь нь Хятад улс эзэлж байна.

Зураг 1. Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт ба бүтэц (сая ам.долл)




Эх сурвалж. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2020. 490 дэх тал (Үндэсний статистикийн хороо, 2020)

Хүснэгт 1. Монгол Улсын ОХУ-тай хийж буй гадаад худалдааны нийт эргэлт, бүтэц(сая ам.долл)

Он	Экспорт	Импорт	Нийт эргэлт
2016	55.8	880.4	936.2
2017	67.7	1 219.2	1 286.9
2018	85.9	1 710.3	1 796.2
2019	68.1	1 729.9	1 798.0
2020	57.3	1 400.0	1 457.3
2021.I-VII	60.8	1 031.7	1 092.5

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2020. 486, 487, 489 дэх тал (Үндэсний статистикийн хороо, 2020)

Зураг 2. Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт ба бүтцэд  
ОХУ-ын эзлэх хувь хэмжээ (хувиар)




Хүснэгт 2. Монгол Улсын БНХАУ-тай хийж буй гадаад худалдааны  
нийт эргэлт(сая ам.долл)<sup>9</sup>

Он	Экспорт	Импорт	Нийт эргэлт
2016	3 901.6	1 061.2	4 962.8
2017	5 307.4	1 427.7	6 735.2
2018	6 542.8	1 968.8	8 537.6
2019	6 789.7	2 060.8	8 850.5
2020	5 4 93.6	1 910.3	7 403.9
2021.I-VII	4 313.8	1 492.7	5 806.5

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2020. 486, 487, 489 дэх тал  
(Үндэсний статистикийн хороо, 2020)

Зураг 3. Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт ба бүтцэд  
БНХАУ-ын эзлэх хувь хэмжээ (хувиар)




Оросын Холбооны Улстай 2016-2019 онд хийсэн гадаад худалдааны нийт эргэлт 936.2 сая ам.доллараас 1798.0 сая ам.доллар болж 92.05 хувиар өссөн бол 2021 оны долдугаар сардын байдлаар 1,092.5 сая ам.доллар болж буурчээ.

БНХАУ-тай 2016-2019 онд хийсэн гадаад худалдааны нийт эргэлт 4962.8 сая ам.доллараас 8850.5 сая ам.доллар болж 78.3 хувиар өссөн бол 2021 оны долдугаар сарын байдлаар 5,806.5 сая ам.доллар болж буурчээ.

Монгол Улсын ОХУ, БНХАУ-тай хийж буй гадаад худалдааны нийт эргэлт буурсан нь цар тахлаас үүдэлтэй худалдаа, эдийн засгийн харилцааны идэвхжил буурсантай холбоотой. Цаашид ОХУ-тай хийх гадаад худалдааны нийт эргэлтийг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцвэргүй байдлыг бууруулахад чиглэсэн шат дараатай арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

Зураг 4. Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн (хувиар)



Зураг 5. Монгол Улсын импортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн (хувиар)




Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 66.1 хувь Азийн орнуудад ногдож байгаагийн 57.7 хувийг БНХАУ-тай хийж байгаа гадаад худалдаа эзэлж байгаа нь дийлэнх хувь, 31.04 хувь Европын орнуудад ногдож байгаагийн 11.32 хувь ОХУ-д ногдож байгаа нь Европын орнуудын эзэлж буй хувиас 19.72 хувиар доогуур байна.

Эдийн засгийн коридор, дэд бүтцийн хөгжил нь хил дамнасан транзит тээврийг хөгжүүлэхэд түлхэц болно. Энэ нь ачаа тээврийн нэвтрүүлэлтийн хүчин чадлын асуудал юм. Энэ нь улс орны хэмжээнд эдийн засгийг хязгаарлах хүчин зүйлсийн нэг болж байгаа бөгөөд энэ нь цар тахлын үед улам бүр тодорхой болж байна (Мөнхжин.А & Дөлгөөн.Б, 2021.10.28).


Хятадаас Европыг холбосон төмөр замаар БНХАУ-ын нийт экспортын 25 хувийг тээвэрлэж байгаа бөгөөд цаашид ч өсөх төлөвтэй байна. Улмаар БНХАУ нэг талаас үйлдвэрлэгч, нөгөө талаас Европ хэрэглэгч бүс нутаг утгаар Монгол Улс логистикийн төв болох боломжтой юм.

Одоогийн байдлаар БНХАУ-аас Европ руу чиглэсэн төмөр замаар тээвэрлэж буй ачааны дөнгөж 15 хувь нь Монголоор дамжин өнгөрч байна (Хишигбат.Г, 2021.11.01). Хос төмөр зам барьж, авто замын дэд бүтцийг сайжруулснаар ирээдүйд томоохон боломж нээгдэнэ гэдэгт итгэлтэй байна.


Зураг 6. Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт дэх Европын орнуудын эзлэх хувь хэмжээ(хувиар)



Зураг 7. Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт дэх Азийн орнуудын эзлэх хувь хэмжээ(хувиар)




Зураг 8. Европын гадаад худалдааны гол түнш орнууд(сая ам.долл.)<sup>12</sup>



Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2020. 486, 487, 489 дэх тал  
(Үндэсний статистикийн хороо, 2020)



Зураг 9. Азийн гадаад худалдааны гол түнш орнууд (сая ам.долл.)<sup>13</sup>

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2020. 486, 487, 489 дэх тал  
(Үндэсний статистикийн хороо, 2020)

Хил орчмын бүс нутгийн худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх нь манай улсуудын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хууль эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, байгаа нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглах зорилгоор 2019 онд “Бүс нутгийн болон хил орчмын хамтын ажиллагаанд түлхэц өгөх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан. Уг хэлэлцээрийг амжилттай хэрэгжүүлэх, бүс нутгийн харилцааг идэвхжүүлэх зорилгоор 2021 оны гуравдугаар сард “Бүс нутгийн хамтын ажиллагааг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх үйл ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хэлэлцээр нь хөрөнгө оруулалтыг татах, хөдөө аж ахуй, байгаль хамгаалах, боловсрол, аялал жуулчлал зэрэг салбарт цаашид хамтран ажиллах таатай орчин бүрдүүлсэн.

Монгол Улсын бараа эргэлтийн бүтцийг сайжруулахын тулд Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бараа, үйлчилгээний жагсаалтыг өргөжүүлж, төрөлжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд бүх төрлийн дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Энэ тохиолдолд мэдээж Москва дахь Монгол Улсын Элчин сайдын яамны дэргэдэх Худалдааны төлөөлөгчийн газар чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд саяхан Алс Дорнодыг холбогч гол хот, Оросыг Ази Номхон

далайн ёус нутагтай холбох Владивосток хотод салбараа нээгээд байна. Энэхүү Худалдааны төлөөлөгчийн газар нь манай хоёр улсын худалдаан-эдийн засгийн харилцааг эрчимжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Монгол Улс, Евразийн Эдийн Засгийн Холбоо(ЕАЭЗХ) хоорондын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх зорилгоор Монгол Улс, ЕАЭЗХ-ны хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны хэсэг байгуулж, түүний хүрээнд идэвхтэй, үр дүнтэй үйл ажиллагаа явагдаж байна. Хамтарсан судалгааны хэсгийн ажил төлөвлөгөөний дагуу үргэлжилж байгаа бөгөөд судалгааны үр дүн энэ онд бэлэн болох юм. Цаашдын үйл ажиллагаа нь эдгээр үр дүнгээс хамаарах бөгөөд сайн үр дүн гарна гэдэгт найдаж байгаа юм.

Монголын бараа бүтээгдэхүүнийг ЕАЭЗХ-ын гишүүн орнуудын зах зээлд нэвтрүүлэхэд саад учруулж буй тарифын саадыг эрс бууруулах замаар манай хоёр улсын худалдааны сөрөг тэнцлийг бууруулах шаардлагатай байна. Үүний тулд Монгол Улс ЕАЭЗХ-д ажиглагчийн статустай болж “Худалдааны чөлөөт бүс” (Азизов.И.К, 2021.11.08) томъёоллын хүрээнд хоёр орны чөлөөт худалдааны давуу тал, харилцан ашигтай байдалд үнэлгээ өгч үр шимийг нь хүртэх боломжтой юм. Одоогоор хөтөлбөрийн хэрэгжилт нь ажлын хэсэг байгуулах, баримт бичигт гарын үсэг зурах шатандаа явж байна.

### **Дүгнэлт**

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн Азийн орнуудтай хийж буй гадаад худалдааны дийлэнх хувийг БНХАУ-тай хийж байгаа гадаад худалдаа, Европын орнуудтай хийж буй гадаад худалдааны талаас бага хувийг ОХУ-тай хийж байгаа гадаад худалдаа эзэлж байгаа нь манай улсын олон улсын худалдааг хөгжүүлэх чухал хүчин зүйлс эдийн засгийн коридор, дэд бүтцийн хөгжил, хил дамнасан транзит тээврийг хөгжүүлэх нь нэн чухал болохыг харуулж байна. Үүнд манай улсын ачаа тээврийн нэвтрүүлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал ч орж байгаа юм. Эдгээр нь Монгол Улсын эдийн засгийг тэлэх хүчин зүйлсийн нэг болж байгаа нь цар тахлын үед улам бүр тодорхой болж байна.

### **Ашигласан материал**

Азизов.И.К. (2021.11.08). Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тохиолдуулан Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизовын мэндчилгээ. *Өдрийн сонин*.

- Батцэцэг.Б. (2021, 07 23). *Орос орон бол бидний хүндэлж явдаг мөнхийн хөри юм*. Retrieved from <https://ikon.mn/>
- Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуула. (2021.11.10). *Монголын үнэн сонин*.
- Мөнхжин.А & Дөлгөөн.Б. (2021.10.28). : Импортыг орлох гэхээсээ илүү экспортлох бүтээгдэхүүндээ хараа чиглүүлэх нь чухал. *Өдрийн сонин*.
- Үндэсний статистикийн хороо. (2020). *Монгол Улсын Статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- Хангай.Л. (2019). Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр. In *Эдийн засгийн коридор ба Монгол Улс* (pp. 157-168). Улаанбаатар.
- Хишигбат.Г. (2021.11.01). Дэлхийн тээвэр логистикт үүсээд буй нөхцөл байдал 2023 он хүртэл үргэлжлэх төлөвтэй. *Өдрийн сонин*.

**Бизнес ба инноваци сэтгүүлийн редакцид илгээх  
зохиогчдын батламж захидал:**

Зохиогч Х.Эрдэнэчулуун, Н.В.Монголова нь сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлсэн гар бичмэлийг өөрсдийн судалгааны үр дүнд тулгуурлан бичсэн, уг бүтээлийг урьд өмнө хэвлүүлж байгаагүй, хэвлүүлэхээр өөр сэтгүүлд илгээгээгүй, бусдын бүтээлийг зохих журмын дагуу ашигласан, судалгааны ажил нь ёс зүйн болон хууль ёсны шаардлагад нийцсэн болно.